



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/64/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Мандалговь хот

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан

Утас: 70593113

Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70593113

Цахим хаяг: Oyunerdenet@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.02.25 № 37

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Х.ЭРДЭНЭТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Р.МӨНХТОГТОХ

0012020759

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>50,901,975.00</u>	<u>65,655,723.00</u>
33	АВЛАГА	4,205,000.00	3,920,500.00
335	Бусад авлага	4,205,000.00	3,920,500.00
3351	Байгууллагаас авах авлага	4,205,000.00	3,920,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	46,696,975.00	61,735,223.00
351	Түүхий эд материал	17,689,856.00	28,211,142.00
35110	Тусгай зориулалттай материал	17,538,552.00	27,772,038.00
35130	Эм боох материал	151,304.00	439,104.00
354	Хангамжийн материал	29,007,119.00	33,524,081.00
35410	Бичиг хэргийн материал	332,500.00	784,950.00
35420	Аж ахуйн материал	26,104,381.00	28,136,581.00
35450	Барилгын засварын материал	1,681,800.00	1,305,600.00
35460	Хүнсний материал	888,438.00	3,296,950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>184,399,880.86</u>	<u>235,408,211.17</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	184,399,880.86	235,408,211.17
392	Биет хөрөнгө	175,577,880.86	226,586,211.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	148,824,362.04	214,701,885.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,205,354.40)	(11,334,510.96)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,579,100.00	42,454,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,449,832.06)	(25,359,888.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,190,966.60	16,115,966.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,853,434.86)	(10,894,971.45)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,965,600.00	2,965,600.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,473,526.46)	(2,061,969.74)
393	Биет бус хөрөнгө	8,822,000.00	8,822,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,822,000.00	8,822,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	<u>235,301,855.86</u>	<u>301,063,934.17</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>476,062.87</u>	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	476,062.87	-
413	Өглөг	476,062.87	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	97,857.87	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	378,205.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>234,825,792.99</u>	<u>301,063,934.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	234,825,792.99	301,063,934.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	89,261,526.00	89,261,526.00
51101	Өмч: - төрийн	89,261,526.00	89,261,526.00
512	Хуримтлагдсан үр дүн	47,095,119.09	113,333,260.27
51210	Өмнөх үеийн үр дүн	47,095,119.09	47,095,119.09
51220	Тайлант үеийн үр дүн	-	66,238,141.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	98,469,147.90	98,469,147.90

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>235,301,855.86</u>	<u>301,063,934.17</u>
---	--	------------------------------	------------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	257,731,100.00	318,083,223.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,695,000.00	67,877,523.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,695,000.00	67,877,523.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,695,000.00	67,877,523.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,695,000.00	67,877,523.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	250,036,100.00	250,205,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	227,288,600.00	224,331,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	227,288,600.00	224,331,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,000.00	170,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,000.00	170,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,597,500.00	25,703,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,597,500.00	25,703,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	242,116,424.09	251,825,081.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	242,116,424.09	251,825,081.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,788,023.09	241,675,949.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,041,080.00	159,880,249.90
210101	Үндсэн цалин	117,740,151.00	117,179,581.00
210102	Нэмэгдэл	28,682,699.00	28,619,889.00
210104	Урамшуулал	14,618,230.00	14,080,779.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,114,056.00	20,839,035.13
210201	Тэтгэврийн даатгал	14,455,556.00	14,991,807.69
210202	Тэтгэмжийн даатгал	1,671,000.00	1,470,578.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,330,200.00	1,173,102.48
210204	Ажилгүйдлийн даатгал	332,600.00	291,231.38
210205	Эрүүл мэндийн даатгал	3,324,700.00	2,912,314.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,882,249.00	20,350,640.00
210301	Гэрэл, цахилгаан	1,208,144.00	1,372,061.00
210302	Түлш, халаалт	18,026,905.00	18,581,579.00
210303	Цэвэр, бохир ус	647,200.00	397,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,879,755.00	7,749,054.00
210401	Бичиг хэрэг	2,707,000.00	327,030.00
210402	Тээвэр, шатахуун	818,300.00	1,540,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	858,080.00	1,011,810.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,800.00	535,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,306,023.00	2,011,600.00
210408	Бараа материал акталсны зардал	2,093,552.00	2,322,514.00
2105	Нормативт зардал	11,220,628.00	7,291,788.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	325,546.00	32,200.00

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	10,895,082.00	7,259,588.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,598,475.00	5,293,150.00
210604	Урсгал засвар	1,598,475.00	5,293,150.00
2107	Томилолт, зочны зардал	700,000.00	388,000.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	388,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	930,000.00	2,197,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	330,000.00	1,957,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	380,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,421,780.09	17,687,032.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	403,656.00	2,787,840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	50,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,018,124.09	14,849,192.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,328,401.00	10,149,132.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,672,400.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	3,375,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	3,375,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,922,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	137,956.00	47,505.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	137,956.00	47,505.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,190,445.00	1,429,227.10
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,190,445.00	1,429,227.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>15,614,675.91</u>	<u>66,258,141.06</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	765,856.22	19,999.88
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	765,856.22	19,999.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(765,856.22)	(19,999.88)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>14,848,819.69</u>	<u>66,238,141.18</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C0 1	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	89,261,526.00	98,469,147.90	32,246,299.40	219,976,973.30
C0 3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	89,261,526.00	98,469,147.90	32,246,299.40	219,976,973.30
C0 7	Тайлант үеийн үр дүн	-	-	14,848,819.69	14,848,819.69
C0 8	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,261,526.00	98,469,147.90	47,095,119.09	234,825,792.99
D0 1	2021 оны 1-р сарын 1-нээрх	89,261,526.00	98,469,147.90	47,095,119.09	234,825,792.99

	үлдэгдэл				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	89,261,526.00	98,469,147.90	47,095,119.09	234,825,792.99
D07	Тайлант үеийн үр дүн			66,238,141.18	66,238,141.18
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	89,261,526.00	98,469,147.90	113,333,260.27	301,063,934.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	250,036,100.00	250,205,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	250,036,100.00	250,205,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	227,288,600.00	224,331,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	227,288,600.00	224,331,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,000.00	170,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,000.00	170,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,597,500.00	25,703,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,597,500.00	25,703,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	236,044,600.00	250,205,700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	236,044,600.00	250,205,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	233,716,199.00	240,056,567.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,076,205.00	159,938,207.90
210101	Үндсэн цалин	117,775,276.00	117,237,539.00
210102	Нэмэгдэл	28,682,699.00	28,619,889.00
210104	Урамшуулал	14,618,230.00	14,080,779.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,340,500.00	20,878,935.00
210201	Тэтгэврийн даатгал	14,682,000.00	15,031,707.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,671,000.00	1,470,578.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,330,200.00	1,173,102.48
210204	Ажилгүйдлийн даатгал	332,600.00	291,231.38
210205	Эрүүл мэндийн даатгал	3,324,700.00	2,912,314.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,504,044.00	20,728,845.00
210301	Гэрэл, цахилгаан	1,208,144.00	1,372,061.00
210302	Түлш, халаалт	17,648,700.00	18,959,784.00
210303	Цэвэр, бохир ус	647,200.00	397,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,620,680.00	7,640,690.00
210401	Бичиг хэрэг	297,700.00	492,480.00
210402	Тээвэр, шатахуун	818,300.00	1,540,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	858,080.00	1,011,810.00
210404	Ном, хэвлэл	89,800.00	355,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн	96,800.00	535,200.00

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,460,000.00	3,705,300.00
2105	Нормативт зардал	11,035,970.00	11,488,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	459,100.00	320,000.00
210502	Хоол, хүнс	10,218,910.00	9,668,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	357,960.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,955,500.00	8,847,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,920,500.00
210604	Урсгал засвар	2,955,500.00	4,927,450.00
2107	Томилолт, зочны зардал	700,000.00	388,000.00
210702	Дотоод албан томилолт	700,000.00	388,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	930,000.00	1,772,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	330,000.00	1,532,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	380,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	553,300.00	8,373,840.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,600.00	3,212,840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	441,700.00	5,161,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,328,401.00	10,149,132.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,672,400.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	3,375,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	3,375,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,922,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	137,956.00	47,505.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	137,956.00	47,505.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,190,445.00	1,429,227.10
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,190,445.00	1,429,227.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>13,991,500.00</u>	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,991,500.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,991,500.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	13,991,500.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,991,500.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(13,991,500.00)</u>	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	250,035,700.00	248,558,967.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	250,035,700.00	248,558,967.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	241,363,300.00	239,886,567.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	160,965,800.00	159,938,207.90
210101	Үндсэн цалин	117,907,400.00	117,237,539.00
210102	Нэмэгдэл	28,520,100.00	28,619,889.00
210104	Урамшуулал	14,538,300.00	14,080,779.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,082,200.00	20,878,935.00
210201	Тэтгэврийн даатгал	15,234,400.00	15,031,707.56
210202	Тэтгэмжийн даатгал	1,470,800.00	1,470,578.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,173,300.00	1,173,102.48
210204	Ажилгүйдлийн даатгал	291,300.00	291,231.38
210205	Эрүүл мэндийн даатгал	2,912,400.00	2,912,314.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,776,300.00	20,728,845.00
210301	Гэрэл, цахилгаан	1,416,400.00	1,372,061.00
210302	Түлш, халаалт	18,959,900.00	18,959,784.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	397,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,642,600.00	7,640,690.00
210401	Бичиг хэрэг	492,500.00	492,480.00
210402	Тээвэр, шатахуун	1,540,900.00	1,540,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,012,800.00	1,011,810.00
210404	Ном, хэвлэл	355,000.00	355,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	535,200.00	535,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,706,200.00	3,705,300.00
2105	Нормативт зардал	11,396,500.00	11,318,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	150,000.00
210502	Хоол, хүнс	9,746,500.00	9,668,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,848,000.00	8,847,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,920,500.00	3,920,500.00
210604	Урсгал засвар	4,927,500.00	4,927,450.00
2107	Томилолт, зочны зардал	388,000.00	388,000.00
210702	Дотоод албан томилолт	388,000.00	388,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,890,000.00	1,772,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,650,000.00	1,532,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,373,900.00	8,373,840.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,212,900.00	3,212,840.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,161,000.00	5,161,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,672,400.00	8,672,400.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	8,672,400.00	8,672,400.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	3,375,000.00	3,375,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,375,000.00	3,375,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,922,400.00	1,922,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	250,035,700.00	248,558,967.90
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	224,331,900.00	222,902,672.90
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	224,331,900.00	222,902,672.90
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,703,800.00	25,656,295.00
122005	Орон нутгийн төсвөөс	25,703,800.00	25,656,295.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	170,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	170,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	170,000.00
2105	Нормативт зардал	170,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	170,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	170,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	170,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Т.Оюун-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ОРЧИН БА ДОТООД ХЯНАЛТ

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэг нь эрхэм зорилгоо “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт, шалгалт хийгдсэн. Хяналт, шалгалтын дүнд 4 зөвлөмж өгөгдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 251,825.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,518.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,762.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,762.1 мянган төгрөгөөр буюу 27.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	4,205.0	3,920.5	-284.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	46,697.0	61,735.2	15,038.2
Үндсэн хөрөнгө	184,399.9	235,408.2	51,008.3
Нийт хөрөнгө	235,301.9	301,063.9	65,762.1
Өр төлбөр	476.1	-	-476.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	234,825.8	301,063.9	66,238.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	235,301.9	301,063.9	65,762.1

Эргэлтийн хөрөнгийн дансанд бараа материалын дансны үлдэгдэл нь 15,038.2 сая төгрөгөөр өссөн нь материаллаг хэмжээтэй ба тусгай зориулалтын материалын өсөлт нөлөөлсөн байна. Тайлант онд цэцэрлэгийн гадна талбайн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авчээ.

Мөн үндсэн хөрөнгийн дансанд барилга, байгууламж 65,877.5 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн хөрөнгөөр засвар хийж, сайжруулалтаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 301,063.9 мянган төгрөг болж 66,238.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.6 ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ ТӨСӨВ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 312,907.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 312,907.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 62,871.5 мянган төгрөгөөр бууруулан 250,035.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 25,703.8 мянган төгрөг, улсын төсвөөс 224,331.9 мянган төгрөг, нийт 250,035.7 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 25,703.8 мянган төгрөг, улсын төсвөөс 224,331.9 мянган төгрөг, нийт 250,035.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд нийт төсвийн 99.4 хувийг зарцуулж, 47.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт, 1,429.2 мянган төгрөгийг улсын төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 170.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 АСУУДЛЫГ ОНЦОЛСОН ХЭСЭГ БА БУСАД АСУУДЛЫН ХЭСЭГ

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд дараах онцлох асуудал байна. Үүнд:

Дулааны эрчим хүчний үйлчилгээг Ган-Илч ХХК-тай гэрээ байгуулан авдаг байна. Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар 14-ний өдрийн 468 тогтоолоор халаалтын үнийг м³ тутамд 1500 төгрөг болгон өсгөснөөс Ган-Илч ХХК нь 19,572.0 мянган төгрөгийн нэхэмжлэхийг ирүүлсэн боловч гэрээнд өөрчлөлт оруулаагүй тул гэрээний үнэ 18,581.6 мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

3.8 АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй буюу шатахууны тооцоог бодож баталгаажуулаагүй, тушаал шийдвэргүйгээр төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон зэрэг зөрчил илэрсэн нь аудитын гол асуудал байна гэж үзлээ.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Цэцэрлэг нь 2021 онд нийт 283,824.6 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчлийг арилгах 10,549.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.